

*Хошууч Б.Амаржаргал - ХСИС-ийн Хууль сахиулахын
удирдлагын академийн 8042 дугаар дамжааны суралцагч.*

хошууч

*В.Пүрэвбаасан -ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн
дэд профессор, хурандаа*

ИХ МОНГОЛ УЛСЫН ҮЕИЙН УДИРДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй: Шинэ зууны менежментийн хандлага болон түүний гол мөн чанарыг Америкийн “Уолл стрит ” сэтгүүлийн 282 том хэмжээний корпораци. 782 нит менежерээс авсан судалгааны үр дүнд “Удирдагчийн амжилт олох хамгийн чухал шинж чанарууд (traits) юу вэ? ” гэдэг асуудлаар гаргаж тавьсан. Унд:

1. Голч шударга чанар (integrity).
2. Ажилсаг шургуу чанар (industriousness).
3. Хумуустэй нийцтэй чанар (ability to get along with people)¹ орсон байдаг.

Энэ бол өиөөдрийн дэлхийн тэргүүлэгч бодлогыг бариж буй Америк менежерийн амжилтад хүрсэн зарчим юм. Уг зарчмыг ХШ зуунд Евразийн улс төр, эдийн засгийн бодлогыг тодорхойлж байсан Чингис хаан өөрийн уйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж байсныг түүхэн сурвалжийн мэдээнд үндэслэн тайлбартайгаар энэ өгуулээр танилцуулах болно.

Түлхүүр үг: Удирдлагын онол, удирдлагын тогтолцоо, харьцуулсан судалгаа, Чингис хаан, Монголын эзэнт гүрэн

Үндсэн хэсэг

Евразийн тэгш өндөрлөг газар хүн үүсэн бий болж, төрт улсууд нэг нь нөгөөхөө мөхөөн дарж, мандан бадарч байсан түүхэн цаг үеүүдэд удирдах, удирдуулах ёс өөрийн хэм хэмжээгээ тогтоон хөгжиж ирсэн уламжлалтай билээ. Монгол улсын газар нутагт мандсан анхны төрт улсыг байгуусан Хүннү нараас эхлэн дэлхийн талыг эзлэн дагуулан Монголын эзэнт гүрний удирдлагын түүхийг ч монголчууд бүрэн гүйцэд судалж чадаагүй юм.

Нүүдэлчин Монгол ахуйгаас төрсөн Мянган жилийн хамгийн алдарт хүн гэж Америкийн "Вашингтон Пост" сонин 1995 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дугаартаа онгөрсөн мянганы хүнээр Чингис хааныг тодруулж "Өнгөрсөн мянган жилд гарсан хамгийн том үйл явдал бол цэвэр нэг л үндэстэн

¹ Wall Street Journal, November 14, 1980, p. 33

дэлхий даяар сүр хүчээ бүрэн төгс илтгэж чадсан” явдал юм хэмээн нийтэлсэн байдаг.

Монголчуудын нэрийг дэлхийн тавцанд ингэж гаргасан хүн бол Чингис хаан бөгөөд түүний удирдагчийн шинж чанарууд, удирдах ур чадвар, арга барил нь удирдахуйн ухааны судалгааны зүйл болж гадаадын эрдэмтдийн анхаарлыг зүй ёсоор татаж байна.

XII-XIV зуун хүртэл асар уудам нутагт янз бүрийн соёл иргэншил, үндэстэн ястан, шашин өөр олон омгийн улс түмнийг Монголын эзэнт гүрний туган дор нэгтгэн зохион байгуулсан үйл явдал нь дэлхийн түүхэнд урьд, хожид хэзээч байгаагүй удирлагын тогтолцоо, Монгол хүний удирдах чадварыг илтгэн харуулсан хөдлөшгүй баримт юм.

Удирдагчийн ур чадварыг хамгийн тод томруунаар харуулж чадсан Чингис хааны удирлагын сэтгэлгээ, үйл ажиллагааны өрнөл, байлдан дагуулалтын цар хүрээ, гаргасан шийдвэрүүдийн мөн чанарыг нь задлан шинжлэх нь Монголын менежментийн түүхийн оргил цэг юм.

Монгол менежмент буюу Монгол удирдлагын мөн чанарыг тухай үеийн түүхэн үйл явдлаас нь татан гаргаж, мөн чанарыг нь тайлбарлах учиртай юм.

Есүхэйн хүү Тэмүжин 17 наснаас цэрэг удирдан олон овог, аймгуудтай их бага тулааныг хийж, 27 насандаа Хамаг Монголын хаанаар өргөмжлөгдөн “Чингис” цолыг авч Хэнтийн нуруунаас Алтай Хянганы уулс хүртэлх өргөн уудам нутгийн өөрийн захиргаанд оруулахдаа удирдах авъяас чадвараа Монгол түмэндээ төдийгүй дэлхийн түүхэнд баларшгүйгээр үлдээж чадсан юм.

Америкийн “Уолл стрит” сэтгүүлийн “Удирдагчийн амжилт олох хамгийн чухал шинж чанарууд (traits) юу вэ?” гэдэг судалгааны дүнд гарсан “Толч шударга чанар (integrity)”, “Ажилсаг шургуу чанар (industriousness)”, “Хүмүүстэй нийцтэй чанар (ability to get along with people)”¹ гэсэн дараах гурван зарчмын Чингис хааны үйл ажиллагаатай холбон задлан шинжилж үзвэл:

1.Голч шударга чанар (integrity) гэдэгт өөрийн хэлсэн үгэндээ үнэнч байх, яриа ба үйл ажиллагаандаа тууштай туйлбартай байх болон захирагдагсдаасаа хүсч байгаа сайн чанаруудыг өөрөө гаргаж харуулах чадварууд (Жишээ нь. захирагдагсдаа үнэнч шударга байлгахын тулд өөрөө үйлдэл, үйл хэргээрээ шударга байх) ордог байна. Тэгвэл Тэмүжин сүүдрээс өөр нөхөргүй сүүлнээс өөр ташуургүй байх үед ирж нийлсэн Боорчи, Зэлмэ хоёроос эхлэн төр улсыг байгуулахад гавъяа байгуулсан нөхдөө хийсэн гавъяаг нь марталгүй, ард язгууртан гэж ялгалгүй (жишээ дурдахад Зэлмэ бол Тэмүжиний зарц байсан)^{1 2}

¹ Wall Street Journal, November 14, 1980, p. 33

² Leadership skills, 2010, bookboon.com, p. 15

мянгат, түмтийн ноёдоор томилж, зарим хүмүүст дархан цол олгож. янз бүрийн хэлбэрээр гүйцэтгэсэн үйл хэргийг нь шударгаар үнэлдэг хүн байжээ.

Тэмүжиний шударга шулуун зан багаасаа тодорч, дээрэлхүү түрэмгий занг тэвчиж чаддаггүй байсан тул нөгөө эхээс төрсөн Бэгтэр Бэлгүтэй хоёрын дээрэнхүй, дээрмийн үйлдэл дахин дахин давтагдах болмогц дүү Хасартай “Ийм бол эдэнтэй яаж хамт амьдарч чадна” гэж ярилцаад Бэгтэрийг 2 талаас нь харван алсан байдаг. Үүний дараа эдний гэр бүлд дахин хэрүүл гарсангүй. үлдсэн Бэлгүтэйг насан туршдаа өөрийн төрсөн дүү шигээ хайрлаж зовлон жаргалаа хуваалцаж ирсэн байдаг билээ.

Ер нь Тэмүжин багаасаа өөрөө зовж ядарч явсан хүний хувьд хүмүүсийг их бага, дээд доод гэж ялгалгүй адил тэгш шударга харьцдаг байсан ба тэдний зовлон жаргалыг мэдэрч найз нөхөр мэт харьцаж, нас барсан хүмүүсийн ар гэрийнхнийг хүртэл харж хамгаалдаг байсан тул олон сайн хүлэг баатар, нөхөдтэй болж тэд нар нь үхэхээс буцахгүй дайн байлдаанд ордог байсны нэг жишээ бол Ван хан. Жамуха хоёртой байлдахад Мангудын Хуйлдар эцээн дайсны өөдөөс бусдын манлай болж явах саналыг өөрөө гаргаж "Тэмүжин андын өмнөөс би байлдъя. Миний хойно хоцорсон өнчин хөвүүдийг асрахыг Тэмүжин анд мэдтүгэй” гэж өөрийн амийг үл хайрлан байлдаанд манлайлан орж шархадсан байдаг.

Чингис хаан дайснуудаа хүртэл шударга үнэлж нөхөрлөж байсан жишээ олон бий. Тухайлбал Тайчуудтай хийсэн байлдаанд Чингис хааны хүзүүг харваж шархдуулсан Зургаадайг үнэнч бөгөөд нөхөрлөж болох хүн гэж үзэж Зөв гэж нэр өгөн дотны ноёноо болгосон, Тайчуудын Таргудай Хирилтугийг барьж авчрах замдаа эзнээ яаж барьж өгөх вэ хэмээн тавьж суллаад өөрөө ирсэн Ширээт өвгөний хүүхдүүд Алаг. Наяа хоёрыг сүүлд мянганы иоён болгосон байдаг юм.

Чингис хаан байлдааны дараа олсон олзыг шударгаар хувааж тараадаг байсан учир дайны цагт түүний цэргүүд олзлон шунадаггүй хамгийн сахилгатай цэргүүд байдаг байжээ. Дайсан дарагдвал олз болон бүх юм нь биднийх болно шүү дээ гэж цэргүүддээ сургадаг байв. 1211 онд Алтан улсыг дайлаар мордоод ирэхдээ манай цэргүүд эд уурсыг өргөж даахуйц ачиж, хив торгоор ачаагаа татаж явж байсан байдаг¹.

Чингисийн голч шударга зан чанарыг бас нэг харуулдаг зүйл бол хүмүүсийн олз ашиганд шунах, хар амиа бодох, урван тэрслэх, тогтоосон цаазыг зөрчих. худлаа ярих, хэлсэн ам, андгай тангарагаасаа буцах (Өглөө хэлснээ үдэш няцаж, үдэш хэлснээ өглөө няцаж явбал ичгүүртэй бишүү. Урьд

¹ Чоймаа Ш. "Монголын нууц товчоо" хөр УБ., 2006. т.123

хэлснээ хатуу барьж явбал дээр биш үү¹) зэрэг ёс зүйгүй, шударга бус үйлдлүүдийг үзэн яддаг байсан ба ийм явдлыг улс дотроо хойшид гаргуулахгүйн тулд хатуу шийтгэдэг байсан нь түүнийг ямар ёс зүйтэй шударга хүн байсныг тодруулж өгдөг билээ. Тухайлбал эзнээсээ урваж, барьж өгсөн Жамухын 5 хүнийг цаазалсан; Сэнгүмийг элсэн цөлд явган хаяад ирсэн агтач Хөхөчүг цавчин алсан. 1202 оны намар татааруудтай байлдах цагт олз ашиганд шунаж байлдаанаас саатан, тогтоосон цаазыг зөрчсөн Алтан. Хучар. Даридай отчигин нарын хаан язгуур угсааг үл харгалзан олзолсон адуу ба юмыг бүрэн хураан авсан; ам тангарагаа зөрчиж ар хударгаар орж ауруг гэрт халдсан жүрхиний Сача бэхи. Тайчу нарыг байлдаж дарсан ба нэгэнтээ нөхөр болж, нөгөө удаадаа өрсөлдөгч дайсан нь болж, Хэрэйд. Найман улсуудын дунд олон жил хутган үймүүлж дайсалнаж байсан Жамухаг өөрийн хүслээр нь хороосон байдаг.

Чингис хаан шударга зангийн улмаас заримдаа хатуу мэт санагдах цээрлэлийн аргууд хэрэглэдэг байсан боловч эдгээр нь “эсгий туургатан энх шударга болж”, нэгдсэн Монгол улсыг байгуулах зорилтыг биелүүлэхэд аргагүй авах ёстой, чухал арга хэмжээнүүд байжээ. Үүний хүчинд ч “орондоо унтах завгүй орчилдон тэмцэлдэж байсан” улс оронд дэг журам, ёс зүй, хууль ёс, энх тайван тогтох бололцоо бүрдэж ирсэн байна.

Түүний гаргасан Их Засаг хуулинд өөрөө бөөгийн шашин буюу Тэнгэрийг шүтэх үзэлтэй хэдий ч “бүх шашныг ялгаварлалгүй хүндэтгэх хэрэгтэй”¹ гэж заасан байдаг бол “байлдааны талбар дээр шархтанаа хамааралгүй орхиж болохгүй”, “харгис ба элбэрэл журамгүй этгээдийг жигшин занах хэрэгтэй”, “хүн алагсдыг алмой”² гэсэн нь шударга энэрэнгүй зан чанарыг нь харуулдаг. Харин энэ хуулинд хулгай хийх, худлаа ярих, завхайрах гэх мэт ёс зүйгүй үйлдлүүдийг хатуу шийтгэхээр тогтоож өгсөн байдаг нь түүний аливаа ёс зүйгүй үйлдлүүдийг жигшин үздэг байсны тодорхой баримт юм. Чингис хааны шударга зан чанарын талаар профессор Х. Пүрэвдагва “Чингис хааны менежментийн товчоон” номондоо “Чингис хаан үнэнч шударга занг хүндэлж, шударга бус, хуурамч занг үзэн яддаг байжээ”⁴ эрдэмтэн Х.Балжинням “Хаан харц 2 нэгэн адил үүрэг. эрхтэй болсон” гэж бичсэн байдаг нь Чингис хааны энэ шинж чанар судлаачдын анхаарлыг аргагүй татдаг болохыг харуулж байна. Италийн жуулчин Монголын түшмэл агсан Марко Поло “Аялалын тэмдэглэл”-дээ “Түүний нийтлэн захирах нь туйлын төв голч бөгөөд найрамдуу, ард иргэн түүнийг хүндлэн хайрлах нь эзэи болсоор шууд

¹ Чоймаа Ш. “Монголын нууц товчоо” хер УБ.. 2006. т. 120

² Ким Жон Рэ. “Мянган жилийн түүхт хүн”, УБ., Сөүл, 1999 т. 182

³ Шагдар Х. “Монголчуудын аян дайн. цэргийн урлагийн түүх (ХП1 зуун)” дэд боть.УБ.. 2000 т. 618

⁴ Пүрэвдагва Х. “Чингис хааны менежментийн товчоон” УБ.. 2004 т. 69

“өөрийн эцэг, эх” мэтээр санана.” гэж тэмдэглэсэн байдаг нь Чингис хааны голч шударга занг ард түмэн хир их хүндлэн хайрлаж биширч байсныг илтгэн үзүүлдэг.

Захирагдагсад удирдагч хүнээс хүсдэг хамгийн гол бөгөөд чухал зүйл бол шударга шагнал. шударга шийтгэл байдаг. Хүмүүс үүргээ сайн гүйцэтгэлээ гэж бодвол тохирсон шагнал хүсч байдаг хэдий ч муу гүйцэтгэсэн үедээ ямар ч хатуу шийтгэл хүлээлгэсэн гомддоггүй. Чингис хаан, хаан цол өргөмжлөгдөөд шинэ Монгол улсын зохион байгуулалтыг хийхдээ улс төрийг байгуулахад гүйцэтгэсэн гавьяагаар нь хүмүүсийг албан тушаалд шударгаар томилж урамшуулж байсан нь гарцаагүй ухаалаг удирдагчийн шинж юм. Тэр тусмаа хүн бүрийн гавьяа зүтгэлийг нэгд нэгэнгүй тоочсон байдаг нь хүний хийсэн үйл ажил, гүйцэтгэсэн үүргийг мартаггүй олон жил санаж явдаг гайхалтай удирдагч болохыг нь харуулдаг. Одоо үеийн удирдагч, менежерүүдэд Чингис хаанаас суралцах зүйл энэ мэт олон байдаг билээ.

Энэ мэтчилэн удирдагч өөрөө ёс зүйтэй, голч шударга, тууштай байж чадвал захирагдагсад нь тэр жишгээр явахыг хичээдэг учраас орчин үеийн менежментийн шинжлэх ухаанд удирдагчийн энэ шинж чанарыг чухалчлан үздэг байна. Энэ шинж чанарын талаар АНУ-ын Ерөнхийлөгч агсан Дуайт Эйзенхауэр “Удирдагч хүний хамгийн дээд зэргийн чанар бол гарцаагүй голч шударга шинж юм” гэж үнэлсэн байдаг¹. Үүнийг дэлхийн II дайны цэргийн томоохон жанжин, дэлхийн хамгийн хүчирхэг гүрний ерөнхийлөгч, олон жилийн удирдах ажлын туршлагатай хүн хэлснээс үзэхүл томоохон хэмжээний удирдагчид зайлшгүй байх ёстой шинж чанар гарцаагүй мөн билээ.

Эндээс үзвэл Чингис хааны голч шударга шинж чанар нь тархай бутархай, хоорондоо дайсагнасан монголчуудыг нэгдмэл төр засагтаа итгэх итгэлтэй болгож, нэгтгэж, сахилга хариуцлагатай, зорилготой болгож, “орондоо унтах завгүй орчилдон тэмцэлдэж байсан” улс оронд шударга ёс, дэг журам, ёс зүй, хууль ёс, энх тайван тогтоход багагүй үүрэг гүйцэтгэсэн байна.

2.Удирдагчийн ажилсаг шургуу чанар (working hardness) бол шинэ сэтгэлгээ, шинэ технологи, шинэ арга барилыг бүтээлчээр хэрэглэн шургуу тэмцэж, зорилгодоо хүрэх чадвар бөгөөд энэ нь удирдагчийн хийсэн бүтээсэн зүйлээр нь илэрдэг билээ.

Чингис хаан хар багаас өнчирч, айлын том хүүгийн хувьд гэр бүлээ тэжээх, овог аймгаа нэгтгэн удирдах том үүрэг хариуцлагыг хүлээсэн нь түүнийг багаас нь ажилч шургуу болгож сургасаа байна. Дээр дурдсан судлаач

¹ Leadership skills. 2010. bookboon.com. p. 16)

профессор Х.Пурэвдагва үүнийг маш оновчтойгоор "Тэмүжиний хүүхэд нас ердөө есхөн жил байсан..." гэж дүгнэсэн байдаг.

Чингис хааны бүтээсэн зүйлсийг харахад л маш их хүч хөдөлмөр, тэвчээр, шургуу чармайлт шаардагдсан нь харагддаг. Тухайлбал 1189 онд буюу 27 насандаа өрсөлдөгч дайсуудтай шургуу тэмцэн, монголын ихэнх овог аймгийг нэгтгэж Чингис хаан цол өргөмжлөгдөж байв. Тэгвэл дэлхийн томоохон цэргийн түүхэн жанжны тоонд ордог Наполеон 27 насандаа дивизийн захирагч, Гитлер Дэлхийн I дайнд ахлах байлдагч цолтой байлдаж явжээ. Харин Македоны Александрын хувьд хаан эцгийн бэлэн ор залгамжилсан тул цэргүүдээ удирдан дайн байлдаанаа эхэлсэн байдаг билээ.

Чингис хаан үеэ өнгөрөөсөн хуучныг өөрчилж, байнга шинийг эрэлхийлж, шинэ техник, технолог, гадаадын эрдэмтэн, мэргэжилтнүүдийг бүтээлчээр ашиглаж чаддаг байсныг эх сурвалжууд болон судлаачид нотолдог юм.

1206 онд буюу 44 насандаа Нэгдсэн Монгол улсыг байгуулан, овог аймгийн хуучин тогтолцоог устган зуут мянгатын системээр эдийн засаг, цэргийн нэгдмэл цоо шинэ засаг захиргааны бүтэц зохион байгуулалт хийв. Монголын ард түмэн нэгдмэл нэг үндэстэн болон хувирч, овог аймгийн дайсангалгүй болж, энх амгалан, хууль зүй, шударга ёсыг тогтоов. Улс орноо гадаадын дайснаас найдвартай хамгаалахын тулд батлан хамгаалах хүчийг шинэчлэн зохион байгуулж чадварлаг тактик стратегитай, дэлхийд хамгийн шилдэг армийг байгуулав. Эрдэмтэн Х.Шагдарын судалгаанаас үзвэл монголын цэрэг нь хүнд, хөнгөн морин цэрэг, явган цэрэг, зэвсэг урлах урчуудыг цэргээс гадна зам гүүр барих, хэрэм цайз нураах төхөөрөмжүүд, дэлбэлэх шатаах хэрэгслүүд хийдэг инженерийн цэрэгтэй, их бууны анги, ар талын ангитай орчин үеийн армиас дутахааргүй зохион байгуулалттай байсан төдийгүй цэргийн тактик стратегийн хичээл судалдаг цэргийн академи (хишигтэн цэргэ)-тай байжээ. Эдгээрээс үзэхэд Чингисийн ямар бүтээлч, үр дүнтэй удирдагч болох нь харагдана.

Чингис хаан Монгол улсыг төвшитгөсний дараа дэлхий ертөншин хэмжээнд даяарчлалыг хийж улс орнуудын дунд энх амгалан тогтоох, харилцан ашигтай арилжаа худалдаа хийх, нэгдмэл зах зээлийг бүрэлдүүлэх үзэл санааг хэрэгжүүлэхийн төлөө амьдралын эцэс хүртлээ тэмцэж иржээ.

Чингис хаан аливаа улс оронд дайн байлдаан хийхдээ эхлээд энх тайванч санал заавал тавьж, эсэргүүцсэн үед л хүч хэрэглэдэг байсныг түүхчид тэмдэглэдэг. Эсэргүүцэн тэмцээд эзлэгдсэн орны ард түмнийг дарлан мөлжөөд байдаггүй, албан татвар оногдуулан удирдагчдыг нь солиод орхидог байсан

олон жишээ дурдаж болох билээ. Чингис хаан аливаа нэг улс орныг хүч түрэмгийлэн булаан эзлэх, дарлан мөлжих, газар баялгийг нь шуан ашиглах, цөлмөн ядууруулах, шашин соёлыг нь устгах, бусад ард түмнийг хүйс тэмтрэх (жишээ нь Гитлер шиг) зорилго тавьж явсан баримт байдаггүйгээс үзэхэд дэлхийн ард түмний сайн сайхны тулд орчин үеийнх шиг даяарчилсан нийгэм дэлхийд тогтоохыг эрмэлзэж явсан байна.

Харамсалтай нь феодалын нийгмийн үеийн жижиг хан, вангууд энэ дэвшилт санааг үл ойлгон өөрийнхөө ард түмний тусыг тулд бус, өөрийнхөө эрх мэдэл, хангалуун амьдралын төлөө эсэргүүцэн тэмцэж монголын шилдэг армид ялагдаж байжээ.

Түүнчлэн улс орнуудаас уран барилгачид, уран дархчууд, эрдэмтэд, авъяаслаг хүмүүсийг цуглуулж албан татвараас чөлөөлж, санхүүжүүлж, шинжлэх ухаан техник технологийн мэдлэгийг хөгжүүлж, үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглаж, дэлгэрүүлж байсан нь үнэн бодит баримт юм.

Түүхчид Чингис хааны гүйцэтгэсэн түүхэн үүргийг сайн муу олон янзаар бичдэг боловч Америкийн эрдэмтэн Жек Ветерфорд "Чингис хаан салангид олон жижиг аймгуудын эринийг эцэслэж, тэднийг худалдаанд суурилсан дэлхийн нэгдмэл тогтолцоонд оруулан, түүхэнд урьд өмнө байгаагүй нэгдмэл гүрэн болгон нэгтгэсэн билээ" гэж дүгнэсэн нь гарцаагүй үнэн билээ. Дашрамд дурдахад даяарчлалын тухай ойлголтонд дэлхий нийтээр 20 дугаар зууны сүүл үед л хүрсэн билээ. Гэтэл харьцангуй соёлжсон 20 дугаар зуунд хүн төрөлхтөн зөвхөн өөрийн улсын өчүүхэн эрх ашиг, бусдын байгалийн нөөц баялгийн төлөө (нөгөө л дундад зууны хан вангуудын адил) 2 удаа дайн хийж 80-аад сая хүнээ алж устгасан боловч энх тайвнаар зэрэгцэн орших, чөлөөт худалдаа хийх, дутагдмал хэрэгцээгээ тайван замаар хангах, хүн ард нь амгалан гайван, баян чинээлэг амьдрах нөхцлийг бүрдүүлж чадаагүй юм. Одоо ч гэсэн дэлхийн хэмжээнд байгалийн нөөц баялгийн төлөө том гүрнүүд ил далд байлдсаар л байна.

Чингис хаан ингэж олон жил "Алд бие минь алдарвал алдартугай, Аху төр минь бүү алдартугай" гэсэн зарчмын үүднээс морин дэлнээс буулгүй, амь насаа хайрлалгүй, тууштай ажиллаж тэмцэж ирсний үр дүнд зуухан мянган цэргийн хүчээр (удирдахуйн ухаан талаас үзвэл маш бага нөөцөөр) "... эзэлсэн газар нутгийн хэмжээ гэхэд Наполеон, Гитлер, Македоны Александрынхыг бүгдийг нь нийлүүлснээс ч илүү 7 сая 770 мянган ам дөрвөлжин километр хүрсэн..."¹ ² Ази Европыг дамнасан, дэлхийд байгаагүй том гүрэн байгуулж, улс ардыг нь түвшитгэж, шударга хууль ёс тогтоож (Дэлхийн түүхэнд анх удаа ...

¹ Жак Уэтерфорд "Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан". П хэйлэл. УБ.. 2012. т. 11

² Ким Жон Рэ, "Мянган жилийн түүхт хүн", УБ., Сөүл, 1999 т.26

Евразийн нутгийн 80% дээр нэгдмэл хууль “Их засаг” үйлчлэв. Б.Балжинням дэлхийн хөгжлийн дараагийн 150-350 жилийн бодлогыг тодорхойлж чадсан¹ байна. Энэ бол түүний хийсэн бүтээсэн зүйл буюу хөдөлмөрч шургуу шинж чанарын үр дүн мөн.

Удирдагчийн ийм ажилсаг шургуу чанар бол өнөө үеийн компани, корпорацийн удирдагч нарт байх заавал байх ёстой шинж чанар бөгөөд үүнийг эрдэмтэн Ким Жон Рэ соргоогоор ажиглаж, өнөөгийн Өмнөд солонгосын залуус, корпорацийн удирдагч нарт Чингис хааны арга барилаар ажиллахыг уриалсан байх нь чухам Чингис хааны ажилсаг шургуу чанарыг хэлсэн бөгөөд энэ нь Монголын, мөн дэлхийн хэмжээний бизнесийн удирдагч нарт хэрэгтэй амьд үлгэр дууриал юм.

3. Хүмүүстэй нийцтэй чанар (ability to get along with people) нь Чингис хаан бага наснаас хүнтэй нийцтэй, бусдын үзэл бодлыг сонсдог, өөрийн үзэл бодлыг хүнд хүчээр тулгадаггүй хүн байжээ. Тэмүжинийг эв эеийг эрхэмлэдэг, нийцтэй хүн болоход “Өэлүн эхийн хүмүүжил ихээхэн нөлөөлсөн бөгөөд эвтэй бол хүчтэй гэдэг гүн ухааны ойлголтыг хүүхдүүддээ суулгасан нь Өэлүн эхийн мөнхийн гавъяа билээ.” Анх 13 настай байхдаа Жамухатай сайн анд нөхөр бололцож^{1 2 3} андын тангарагийг баримтлан нөхөрлөж ирсэн ба түүнийг ялагдаад баригдаад ирэхэд ч гэсэн найз нөхөр хэвээрээ байх санал тавьж байсан, огт танихгүй Боорчитой нөхөрлөсөн, зарц болгож өгсөн Зэлмэ-г өөрийн нөхөр мэт үзэж харьцдаг байсан зэргээс үзэхэд Тэмүжин багаасаа дээрэлхүү, бардам ихэмсэг зангүй бөгөөд хүнтэй нийцтэй хүн байсныг нотолж байна.

Жамухаас салсны дараа Монголын язгууртнууд түүн дээр цуглаж Тэмүжинийг хаан өргөмжлөхөд өөрөө Алтан, Хучар, Сача бэхи, Тайчу зэрэг хаан гарлын язгууртнуудыг “Чи хаан бол” гэж тус бүрт нь санал болгож байсныг үзэхэд Монгол улсын эв нэгдлийн төлөө бусадтай эв эстэй байж, нийцэж ажиллахыг хичээж байсан байдаг.

Түүнчлэн Чингис хаан өөрөө эхэлж дайн байлдаан сэдээд байсангүй, голдуу гадна талаас дайн өдөөж байсан харагддаг. Тухайлбал тайчууд, мэргидүүд Тэмүүжинг бага балчир байхаас нь дээрэлхэн довтолж өөрийг нь болон эхнэрийг нь олзлон аваачиж дайсгагнаж байсан учраас л тэдний эсрэг тэмцэхээс өөр аргагүй болсон. Хэрэйд, Найман, Жамух нар л дайныг эхэлж өдөөсөн, мөн Сартуулын султаны эсрэг Монголын ард түмэнд дутагдаж буй бөс даавуу, үр тариа, бусад барааны төлөө буюу чөлөөт арилжаа наймааны төлөө аргагүйн эрхэнд тулалдах хэрэгтэй болсои байдаг.

¹ Балжинням Б. "Монголын түүхийн товчоон", УБ., т. 783

² Пүрэвдагва Х. "Чингис хааны менежментийн товчоон" УБ., 2004. т. 40

³ Чоймаа У.Ж. "Монголын нууц товчоон" хор УБ., 2006. т. 39

Чингис хааны үйл ажиллагаанд шударга бус үйлдэл хийсэн хүнийг л хатуу шийтгэдэг байснаас бусдаар хүнийг алаглаж үздэггүй, гадаад дотоод, нөхөр дайсан, харь болон өөрийн овог аймаг, баян ядуу гэлгүй хүн бүртэй нийцэж харьцаж чаддаг чанар ажиглагддаг.

Хүнтэй нийцтэй байх талаар Чингис хааны өөр нэг арга бол аливаа зөрчил тэмцлийг хоёр талын эрх ашгийг бодолцож, хүчээр бус, эв зүйгээр, дипломат аргаар шийдвэрлэхийг хичээдэг байсан явдал юм. Тухайлбал, өөрөө дөнгөж хаан өргөмжлөгдөөд Тоорил ханд Тахай, Сүхэхэй хоёрыг элч болгон илгээж найрсаг харилцаа тогтоох, энх тайванч санаагаа илэрхийлж байсан байдаг. Жүрхин нартай зөрчилдөхөд хүлээцтэй байж буулт хийн Хорижин хатан, Хуурчин хатныг буцааж өгч байсан. Хэрэйд улстай дайн тулаангүй амар тайван байа гэж сэтгээд Зүчид Сэнгүмийн дүү Чаурбэхийг гуйж бас Сэнгүмийн хөвүүн Тусахад өөрийн Хожин бэхийг өгье гэж санал тавьж байсан юм.

Судлаач Б.Балжинням "Монголчууд төвшитгөсөн ард түмнүүддээ хэзээ ч ертөнцийг үзэх үзэл, ёс заншил, хэл, шашин гэх мэт амьдралын хэвшлээ тулган хүлээлгэж байсангүй. Энэ бүхэн өнөөгийн хүн төрөлхтөнд нэн чухал үлгэр мөн"¹ гэж дүгнэсэн байдаг нь Чингис хааны үзэл бодлоо бусдад тулгадаггүй зан болон үүнийг нь өвлөн авсан түүний залгамжлагчдын үйл ажиллагааны талаарх чухал дүгнэлт юм.

Дүгнэлт

Монголчууд нүүдлийн нийгмээс суурин соёл иргэншил рүү сүүлийн 100 жилд шилжихдээ өрнөдийн олон хувьсалыг өөриймшүүлэн төлөвшүүлсэн нь гадны онол, харийн соёл, бусдын сэтгэлгээг өөрсдийн үнэт зүйлсийн дээр тавьснаар илэрч, үүний үр дүнд олон сайхан дотоод мөн чанараа алдаж байна. Үүний нэгэн тод жишээ нь бидэндХП-ХIV зууны дэлхийн түүхэн хүрдийн өөрсдийн гараар эргүүлсэн өвөг дээдсийн минь мэргэн ухаан байсаар байтал харийн үзлийн өмнө өвдөг сөхрөх болсон бөгөөд Чингис хааны удирлагын асуудлыг судлаагүй, судалсан зүйлсээ амьдралд хэрэгжүүлээгүй, үр хойчдоо өвлүүлж чадаагүй явдалтай холбоотой.

Иймд энэ асуудлыг өөрийн хэмжээнд дахин сохож тавихдаа өрнөдийн удирдлагын шинжлэх ухааны онол, судалгааны үр дүнд хамгийн шилдэг, мундаг гэсэн тэр ойлголтууд Монголчуудад тэр тусмаа Чингис хааны удирдлагын зарчимд хэрхэн тусаж байсан юм бэ гэдгийг л энэ өгүүллээрээ хөндөн тавьсан болно. Монгол эцэг хүн бүрийн үр хүүхэддээ “эр хүн ноён нуруутай байх, буурь суурьтай хөдлөх, асуудалд тулхтай хандах” гэх мэт хэлж сургаж, төвөлшүүлдэг мөн чанар нь Монголчуудын үр хүүхдээ сургаж

ирсэн уламжлалт ухааны нэгээхэн хэсэг нь юм. Өөрөөр хэлбэл үр хүүхэд бүртээ

- Шудрага байх
- Ажилсаг байх
- Эв ээтэй байх тухай сургаж ирсэн уламжлал нь Монгол язгуур ухаанаас үүсэлтэй юм.

Чингис хаан дөрвөн өнгө, таван харь улсыг төрийн нэгэн жолоонд оруулан нэгтгэн захирсан явдал нь эцэг өвгөдийн уламжлал. Өэлүн эхийн сургаалиар хүмүүжихдээ олж авсан хүний "биеийг татахаас илүү сэтгэлийг нь татаж чадсан" мөн чанарт нууц нь оршино. Энэ бол өнөө цагийн хэллэгт "удирдагчийн ур чадвар" юм.

Дэлхийн улс төр, эдийн засагт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгаа Америкийн 300 шахам удирдагчийн дунд хийсэн судалгааны үр дүнд олж илрүүлсэн дээрх гурван зарчмийг бид ганхцан Чингис хааныхаа үйл ажиллагаатай холбон задлахад энэ мэт байна. Монгол хаадынхаа ур ухааныг задлан шинжилж гарган ирсэн удирдлагын зарчмуудыг нарийвлан судлах, уламжлал ба шинэ үеийн ололт дэвшлийн харьцуулан шинжлэх зайлшгүй шаардлага байна гэдэг нь илэрхий байна.

Энэ нь Монгол удирдагч нарын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болох, хамт олноо сайн удирдахад жинхэнэ жанжин шугам, алсын хараа, гол ноён нуруу нь болох юм.

Бидний Монголчууд бусдын түүх, харийн соёл, гадны удирдагч нараас хол илүү ухаан төгс өвгөд дээдэстэй гэдгээ мэддэг боловч, түүхээсээ суралцаж чадахгүй, амьдралдаа хэрэгжүүлж чадахгүй байгаад л өнөөдрийн Монголыг бүтээж байна. Иймд энэ судалгаа цааш үргэлжлэн судлагдах болно гэдгийг энэхүү өгүүлэлээрээ уламжилж байна.

Ашигласан материал

1. Wall Street Journal November 14. 1980.
2. Wall Street Journal November 14. 1980.
3. Leadership skills. 2010, bookboon.com.
4. Чоймаа Ш. "Монголын нууц товчоо" хөр УБ., 2006.
5. Чоймаа Ш. "Монголын нууц товчоо" хөр УБ., 2006.
6. Ким Жон Рэ, "Мянган жилийн түүхт хүн", УБ., Сөүл. 1999.
7. Шагдар Х. "Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх (ХШ зуун)" дэд боть.УБ., 2000
8. Пүрэвдагва Х. "Чингис хааны менежментийн товчоон" УБ., 2004
9. Leadership skills. 2010, bookboon.com.
10. Дорж Б."Чингис хааны менежментийн товчоон" УБ., 2004.
11. Жак Уэтерфорд "Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан". II хэвлэл. УБ., 2012.
12. Ким Жон Рэ, "Мянган жилийн түүхт хүн", УБ., Сөүл, 1999.
13. Балжинням Б. "Монголын түүхийн товчоон", УБ.,
14. Пүрэвдагва Х. "Чингис хааны менежментийн товчоон" УБ., 2004.
15. Чоймаа Ш. "Монголын нууц товчоон" хөр УБ., 2006.
16. Балжинням Б. "Монголын түүхийн товчоон" УБ.,
17. Минжин Ц. "Их засаг" УБ.,2009
18. Цэрэнбалтав С. Минжин Ц. "Тэмүжин чингис хааны намтар" I-III боть, УБ., 2002, 2006.